



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 03 сарын 14 өдөр

Дугаар А/92

Арвайхээр

Тендерийн гүйцэтгэгчийг сонгох тухай


Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 46 дугаар зүйлийн 46.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны 2020 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн 18 дугаар дүгнэлтийн дагуу аймгийн Мал эмнэлгийн газарт 2020 онд хэрэглэгдэх шатах тослох материал, түлш нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендерийн багц-1 Шатахуун, шатах тослох материал багцыг 20022595 (хорин сая хорин хоёр мянга таван зуун ерэн тав) төгрөгөөр НИК ХХК-иар, багц-2 Түлш, халаалт нүүрс багцыг 17402000 (арван долоон сая дөрвөн зуун хоёр мянга) төгрөгөөр Түшиг вилла ХХК-иар тус тус нийлүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Гэрээнд байгуулан бараа нийлүүлэх явцад хяналт тавьж, гэрээнд заасан хугацаанд хүлээж авахыг аймгийн Мал эмнэлэгийн газар (А.Нямдаваа)-т даалгасугай.

3. Гэрээнд заасан хуваарь, гүйцэтгэлийн дагуу санхүүжилт олгохыг аймгийн Мал эмнэлэгийн газар (С.Эрдэнэчимэг)-т зөвшөөрсүгэй.

ДАРГА



Ц.ГАНБОЛД